



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/57

Модот

**Ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 11 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газрын дуудлага худалдааны ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга (Ү.Ичинхорлоо) - Засаг даргын Тамгын газрын дарга

Дуудлага худалдааны

хөтлөгч: (Я.Отгонтуяа) - Газрын даамал

Тэмдэглэл хөтлөгч: (А.Гансүх) - Хүнс хоршоо жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

2. Газрын дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Ү.Ичинхорлоо)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А. МӨНХ-ОРГИЛ

